

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй:

1/13<sup>2</sup> дугаар зүйл:

\*13<sup>2</sup> дугаар зүйл. Цэргийн тагнуулын байгууллага

13<sup>2</sup>.1.Цэргийн тагнуулын байгууллага нь Монгол Улсын Зэвсэгт хүчний удирдлагыг Үндэсний аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхолд нийцсэн цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн тагнуулын мэдээллээр хангах үндсэн чиг үүрэг бүхий цэргийн байгууллага мөн.

13<sup>2</sup>.2.Цэргийн тагнуулын байгууллагыг Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчтай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газар байгуулж, өөрчилж, татан буулгана.

13<sup>2</sup>.3.Цэргийн тагнуулын байгууллагын дүрэм, ажиллах журмыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга болон Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар батална.

13<sup>2</sup>.4.Цэргийн тагнуулын байгууллага үйл ажиллагаагаа явуулахад Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон энэ хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө.

13<sup>2</sup>.5.Цэргийн тагнуулын байгууллага бэлгэ тэмдэгтэй байна. Бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга батална.

2 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

\*1/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг

"9.1.Монгол Улсын тагнуулын байгууллагын тогтолцоо нь тагнуулын төв байгууллага /цаашид "Тагнуулын ерөнхий газар" гэх/, түүний төв, орон нутаг дахь салбар, нэгж болон цэргийн тагнуулын байгууллагаас бүрдэнэ."

3 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн "цэрэг-стратегийн тагнуул" гэснийг, 10.10.6 дахь заалтын "цэрэг-стратегийн болон" гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.14 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.17 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2022 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг